



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 9 сарын 15 өдөр

Дугаар 60

Дархан

**ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКЫН
БҮС ТОГТООХ ТУХАЙ**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.1 дүгээр заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймгийн Дархан үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх үйлдвэрлэлийн бүс нэгийн байршлыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэрлэлийн бүс хоёрын байршлыг хоёрдугаар хавсралтаар, сургалт эрдэм шинжилгээний бүсийн байршлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх бүсэд Дархан үйлдвэрлэл технологийн парк байгуулахыг аймгийн Засаг дарга /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГҮНЧИН

0100190